

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ
ЭМ ЗҮЙН СУРГУУЛЬ

Намнандоржийн Номин-Ундрaм

**Цочмог В вирус гeпатитын стационарын
эмчилгээний эмийн хэрэглээнд хийсэн
маркетингийн судалгаа**

Е 720154 – Эм зүй

Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл

УЛААНБААТАР ХОТ
2007 он

Магистрын судалгааны ажлыг ЭМШУИС (Захирал, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Ц.Лхагвасүрэн), Эм зүйн сургууль (Захирал, Эм зүйн ухааны доктор, профессор С.Цэцэгмаа), Эм зүйн албаны зохион байгуулалт, эмийн технологийн тэнхим (Эрхлэгч, Эм зүйн ухааны доктор Ц.Даваасүрэн)-д хийж гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Эм зүйн ухааны доктор, дэд профессор Р.Цэрэнлхагва

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Эм зүйн ухааны доктор О.Уранчимэг

ГАРЧИГ

Удиртгал	1
Судалгааны ажлын үндэслэл	1
Судалгааны ажлын зорилго, зорилтууд	2
Нэгдүгээр бүлэг. Хэвлэлийн тойм	5
1.1. Вирус гепатитын эмгэг жам этиологи, тархалтын байдлын товчоос	5
1.2. Монгол улс дахь вирус гепатитын тархалтын байдлаас	10
1.3. Цочмог (ЦВГ) болон архаг (АВГ) В гепатитын тодорхойлолт, эмнэлзүйн онцлог, оношлогооны товчоос	11
1.4. Вирус гепатитын эмчилгээ ба түүний явцын талаар	13
1.4.1. Архаг В гепатитын вирусын эсрэг эмчилгээ	16
1.4.2. Халдварт өвчин судлалын үндэсний төвд цочмог В вирус гепатитын стационарын эмчилгээнд мөрдөж буй эмчилгээний стандарт	19
1.5. Эмийн хэрэглээг судалж, эрэлт хэрэгцээг тодорхойлох маркетингийн үзэл баримтлал	21
Хоёр дугаар бүлэг. Судалгааны материал, арга зүй	28
2.1. Монгол улсын хүн амын гепатитын өвчлөлийн судалгаа	28
2.2. Цочмог вирус В гепатитын өвчний эмчилгээний эмийн хэрэглээ	29
2.3. Стационарын өвчтөнүүдийн эмчилгээний эмийн хэрэглээг судалсаны үндсэн дээр эмийн хэрэгцээг өвчлөлийн үзүүлэлтээр тодорхойлсон нь	31
2.4. Амбулаторийн болон стационарын өвчтөний эмчилгээний эмийн хэрэгцээг тодорхойлсон нь	33
2.5. Судалгааны материалын боловсруулалт.....	34
Гуравдугаар бүлэг. Судалгааны үр дүн	35
3.1. Монгол улсын хүн амын дунд тохиолдох вирус гепатитын өвчлөлийг Эрүүл мэндийн статистикийн тайлангаас авч судалсан дүн	35
3.2. Цочмог вирус В гепатиттай өвчтөний эмчилгээний эмийн хэрэглээнд хийсэн судалгааны үр дүн	38
3.3. Цочмог В вирус гепатит өвчнөөр стационарт эмчлэгдэх өвчтөнүүдийн эмчилгээний эмүүдийн хэрэгцээг тодорхойлсон нь	39
3.3.1. ДЭМБ-аас зөвлөмж болгосон “Эмийн хэрэгцээг өвчлөлөөр тооцох” аргаар тодорхойлсон дүн	39

3.3.2. Эмийн хэрэгцээг өвчлөлийн прогнозад тулгуурлан хэрэглээ буюу зарцуулалтаар тооцох аргаар тодорхойлсон дүн	46
Дөрөвдүгээр бүлэг. Судалгааны үр дүнгийн хэлцэмж	54
4.1. Вирус гепатитын өвчлөл, цочмог В вирус гепатиттай өвчтөнүүдийн стационарын эмчилгээ, гол нэр төрлийн эмийн хэрэглээ	54
4.2. Цочмог В вирус гепатит өвчнөөр стационарт эмчлэгдсэн өвчтөнүүдийн эмчилгээний эмүүдийн хэрэглээг судалж, хэрэгцээг тодорхойлсон нь	57
Дүгнэлт	60
Ашигласан ном хэвлэл	61
Судалгааны ажлын үр дүнгээр гаргасан аргачлал	64
Цочмог В вирус гепатит өвчний стационарын эмчилгээний эмийн хэрэгцээг тодорхойлох нь	64
Товчилсон үгийн жагсаалт	72
Гарчиг	73

Удиртгал

Судалгааны ажлын үндэслэл

ДЭМБ-ын мэдээлж байгаагаар манай дэлхийн хүн амын 3-ны нэг нь В гепатитын, 500 гаруй сая хүн С гепатитын халдвар авсан байгаа бөгөөд вирусын халдварын улмаас элэгний хавдраар жилдээ 1 сая орчим хүн нас бардаг байна.

Манай судлаачдын судалгаагаар Монгол улсын хүн амын 33%-нь вируст гепатитын, тэдгээрийн 56.1%-нь буюу 351.2 мянган хүн С вирусын халдвартай, хавдраар нас барагсадын 44.2%-нь элэгний хавдраар нас барж байна.

Монгол улсын хүн амын нийт өвчлөлийн тэргүүлэх таван шалтгааны хоёрдугаарт хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл, түүний дотор элэгний эмгэг стационарын өвчлөлийн 24.9%-ийг эзэлж эхний байранд орж байна.

Вируст гепатитын өвчлөл халдварт өвчнүүдийн дотор 18.5%-ийг эзэлж 10000 хүн амд 26.2 байгаа (Эрүүл мэндийн статистикийн 2006 оны тайлангаар) бөгөөд эдгээрийн дотроос цочмог болон архаг вируст гепатит В-гийн өвчлөл 0.3%-иар нэмэгдэж, өвчлөл өсөх хандлагатай байна.

Аль ч улс оронд хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах асуудал эмнэлэг, эм зүйн тусламжийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг бөгөөд дэлхийн олонхи улсад, ялангуяа хөгжиж байгаа орнуудад эм хангамжийн асуудал бэрхшээлтэй, хүндрэлтэй байсаар байна.

Дэлхийн зах зээлд нийлүүлэгдэж байгаа эмийн 85% нь өндөр хөгжилтэй орнуудад, үлдэх 15% нь дэлхийн хүн амын дөрөвний гурван хувь нь амьдардаг хөгжиж байгаа орнуудад ноогддог ба Латин Америкийн орнуудад 6%, Азийн орнуудад 7%, Африкийн орнуудад 2% байна.

Цочмог вируст гепатит В-гийн халдвартай стационарын өвчтөнүүдийг эмээр хангах ажил нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чухал асуудлын нэг байсаар байна. [11,12,14,27,33].

Гастроэнтерологи, гепатологийн практикт болон халдварт өвчнүүдийн эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалтын эмийн хэрэгцээний хэтийн прогнозыг гаргах онолын үндэслэлийг гадаад орнуудын судлаачид (Л.В.Кобзарь, Н.Б.Дремёва, Т.И.Тольцман, З.М.Мнушка зэрэг олон судлаачид) тавьсан хэдийч, манай оронд цочмог вируст гепатитын эмчилгээний эмийн эрэлт, хэрэгцээг судлах талаар хийгдсэн судалгааны ажил үндсэндээ байхгүй байгаа болно. [28-32].

Дээр дурдсан нөхцөл байдал, шаардлага нь энэхүү сэдвийг сонгон авч судалгаа явуулах үндэслэл болж өгсөн юм.

Судалгааны ажлын зорилго, зорилтууд

Цочмог вирус В гепатиттай өвчтөнүүдийн эмчилгээний үндсэн эмүүдийн хэрэглээг судалж, хэрэгцээг тодорхойлох, зохистой ашиглах үндэслэлийг гаргахад судалгааны ажлын зорилго чиглэгдэнэ.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлсэн юм.
Үүнд:

1. Цочмог вирус гепатит В-гийн өвчлөлийн бүтэц, тархалтыг Монгол улсын Эрүүл мэндийн статистикийн тайлан, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн (ХӨСҮТ) статистикийн 1999-2006 оны тайлангаас судлан, үзүүлэлтүүдийг олон жилийн дунджаар тооцоолон, өвчлөлийн прогнозыг гаргах
2. ХӨСҮТ-ийн гепатитын тасагт 2006 онд стационараар эмчлэгдсэн цочмог В вирус гепатиттай өвчтөнүүдийн эмчилгээнд хэрэглэсэн үндсэн нэр төрлийн эмийн бодит хэрэглээг өвчний түүхээс түүвэрлэн авч нэгтгэн судлах, эмийн хэрэглээний талаар мэргэжлийн эмч (шинжээч) нараас социологийн судалгаа авч дүгнэлт хийх
3. Сонгож авсан цочмог В вирус гепатиттай өвчтөний стационарын эмчилгээнд хэрэглэсэн эмийн бодит зарцуулалтанд үндэслэн уг эмүүдийн жилийн хэрэгцээг нэр төрөл, тоо хэмжээгээр өвчлөлийн прогностой уялдуулан тодорхойлох
4. Цочмог вирус В гепатиттай өвчтөний стационарын эмчилгээнд хэрэглэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрлийн жагсаалтыг гаргаж, тэдгээрийн хэрэгцээг тооцох зөвлөмж аргачлал боловсруулах.

Судалгааны объект ба материал:

Монгол улсын хүн амын Эрүүл мэндийн статистик, ХӨСҮТ-ийн статистикийн алба, мөн төвийн гепатологийн тасгийн архаг болон цочмог вирус гепатитын тасагт эмчлэгдсэн өвчтөнүүдийн өвчний түүх, эмчилгээнд зарцуулсан эмийн түүвэр, өртөг, эмийн захиалга, тасгийн эрхлэгч, эмч нар болон зөвлөх эмч, эрдэмтдийн асуумж судалгаа

Судалгааны арга:

Судалгааг явуулахдаа интенсив, экстенсив үзүүлэлтүүдийг түүвэрлэх, бүлэглэх, харьцуулах, боловсруулалт хийх, үнэлэлт дүгнэлт гаргах, баталгаажуулах, график дүрслэлээр шинжилгээ хийх зэрэг статистикийн аргууд,

өвчлөлийн тархалтын судалгаа, социологийн асуулга (асуумжийн болон анкетийн арга), фармакоэпидемиологийн болон эмийн хэрэглээг судлах, хэрэгцээг тодорхойлох маркетингийн аргуудыг ашиглав.

Судалгааны материалын боловсруулалтыг компьютерийн Word, Excel, SPSS-10 зэрэг программуудыг ашиглан хийв.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Цочмог вирус В гепатитын өвчлөлийн динамикийг олон жилээр судалж, өвчлөлийн прогнозыг гаргасны үндсэн дээр тэдгээрийн стационарын эмчилгээнд хэрэглэх гол нэр төрлийн эмийн хэрэгцээг тооцон гаргаж, шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолон эмийг зохистой хэрэглэх, хөрөнгийг оновчтой зарцуулах үндэслэлийг гаргаж тавьлаа.

Энэ утгаараа Монгол улсын хэмжээнд болон тодорхой бүс нутаг, эмнэлгийн хүрээний хүн амын дунд түгээмэл тохиолдох аюултай, тархалт ихтэй элэгний эмгэг болох цочмог вирус В гепатитийн эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмийн хэрэгцээг хэрэглээ, эмчилгээний стандарт, өвчлөлийн прогнозтой уялдуулан тооцож, эмийн хангалт нийлүүлэлтийг үндэслэлтэй хийж, зохистой хэрэглээг бүрдүүлэх суурь судалгааны ажил болж байгаа юм.

Судалгааны ажлын шинжлэх ухааны ба практикийн ач холбогдол:

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн клиникийн эмнэлэгт цочмог вирус В гепатитаар стационарт эмчлэгдсэн өвчтөнүүдийн эмчилгээнд хэрэглэсэн үндсэн эмүүдийн хэрэглээнд фармакоэпидемиологийн судалгааг явуулж дараах үр дүнг гарган авч, онолын болон практикийн ач холбогдолтой болсон юм. Үүнд:

1. Цочмог вирус В гепатитийн үед эмчилгээнд хэрэглэх эмийн нэр төрлийг тогтоолоо.
2. Цочмог вирус В гепатиттай өвчтөнүүдийн стационарын эмчилгээнд хэрэглэгдэх эмийн жилийн хэрэгцээг тооцож гаргав.
3. Цочмог вирус В гепатиттай өвчтөнүүдийн стационарын эмчилгээний эмийн хэрэглээг судалж, хэрэгцээг тооцож гаргах аргачлал боловсруулав.
4. Цочмог вирус В гепатиттай өвчтөнүүдийн стационарын эмчилгээнд хэрэглэгдэх эмэнд зарцуулах хөрөнгийн хэмжээг тооцож, төсвийг оновчтой зарцуулахад баримтлах үндэслэлийг гаргаж тавьлаа.
5. Шаардлагатай эмийн хэрэгцээг тодорхойлон гаргаснаар эмийг зохистой ашиглах үндэслэлийг гарган тавьж байгаа юм.

MARKET STUDY ON DRUG USE FOR INPATIENT TREATMENT OF ACUTE HEPATITIS B

N.Nomin-Undram¹, R.Tserenkhagva²

- 1- Master of School of Pharmacy
- 2- Supervisor of the study, teacher of Department of Pharmaceutical
Management and Pharmaceutical Technology, School of Pharmacy

Keyword: Hepatitis B virus (HBV), acute hepatitis B, infectious diseases, main medicines used for treatment for patients, prognosis of illness.

According to World Health Organization, one third of world's population is infected by hepatitis B and over 500 million people are infected by hepatitis C and approximately 1 million people die due to the liver cancer each year.

According to studies in Mongolia, 33% of population of Mongolia is infected by hepatitis. 56.1% of them or 351.2 thousand people – by virus C, 44.2% of people, who die due to cancer, have liver cancers.

Diseases of digestive system in Mongolia are the 2nd of the top 5 reasons of most-spread diseases and liver disorder occupies 24.9% of them.

When the average indicator of proportion of all types of virus hepatic diseases and hepatitis A, B and other virus are estimated from total infectious diseases in 8 year period then the proportion of patients inflicted by the hepatitis B from all virus hepatitis patients is 10.74% and it was established that average 799±46 patients are involved into stationary treatment from the acute hepatitis B at the hospitals every year.

For the treatment of acute hepatitis B patients among Mongolian population and it was required to use the medicines for total 13749.71±791.6 thousand tugrugs according to which for one patient required the medicine for 17.21±0.99 thousand tugrugs.

Without involving Interferon used for the treatment against virus there forecasted the need for medicines of 124577.66±7172.2 thousand tugrugs.

Цочмог В вирус гепатитын стационарын эмчилгээний эмийн хэрэглээнд хийсэн маркетингийн судалгаа

Н.Номин-Ундрэм¹, Р.Цэрэнлхагва²

- 1- Эм зүйн сургуулийн магистр
- 2- Судалгааын ажлын удирдагч, Эм зүйн сургуулийн Эмийн зохион
байгуулалт ба эмийн технологийн тэнхимийн багш

Түлхүүр үг : В вирус гепатит (HBV), цочмог В вирус гепатит, халдварт өвчин, стационарын өвчтөнд хэрэглэдэг нийтлэг эм, өвчлөлийн прогноз.

ДЭМБ-ын мэдээлж байгаагаар манай дэлхийн хүн амын 3-ны нэг нь В гепатитын, 500 гаруй сая хүн С гепатитын халдвар авсан байгаа бөгөөд вирусын халдварын улмаас элэгний хавдраар жилдээ 1 сая орчим хүн нас бардаг байна.

Манай судлаачдын судалгаагаар Монгол улсын хүн амын 33%-нь вирус гепатитын, тэдгээрийн 56.1%-нь буюу 351.2 мянган хүн С вирус халдвартай, хавдраар нас барагсадын 44.2%-нь элэгний хавдраар нас барж байна.

Монгол улсын хүн амын нийт өвчлөлийн тэргүүлэх таван шалтгааны хоёрдугаарт хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчлөл, түүний дотор элэгний эмгэг стационарын өвчлөлийн 24.9%-ийг эзэлж эхний байранд орж байна.

Нийт халдварт өвчинд бүх төрлийн вирус гепатит болон А,В болон бусад вирус гепатит өвчний эзлэх хувийг 8 жилийн дунджаар тооцоолж гаргахад вирус гепатитаар өвчлөгсдийн дотор В вирус гепатитын эзлэх хувийн жин 10.74% байгаа ба жилдээ дунджаар 799 ± 46 хүн цочмог В вирус гепатит өвчний улмаас эмнэлгийн стационарт эмчлэгдэх болох нь тогтоогдлоо.

Монгол улсын хүн амын дунд тохиолдох цочмог В вирус гепатитаар өвчлөгсдийн стационарын эмчилгээнд жилдээ 13749.71 ± 791.6 мянган төгрөгийн буюу нэг өвчтөнд 17.21 ± 0.99 мянган төгрөгийн эм хэрэгцээтэй, вирусын эсрэг эмчилгээний интерфероныг оролцуулахгүйгээр 2008-2015 онд прогнозоор 124577.68 ± 7172.2 мянган төгрөгийн эм шаардлагатай болохыг тогтоолоо.